

# 2026 оны төсөв: Онцлог, өөрчлөлт, эрсдэл

Б.Ананд, О.Ариунзаяа  
2025.09.17

# Агуулга

**01** 2026 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСЛИЙГ ӨРГӨН БАРИВ

**02** ЗАРЛАГЫН ӨСӨЛТӨӨ ТАНАХААС ӨӨР  
ГАРЦГҮЙ БОЛОВ

1. ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН Ч ХУВИЙН ХЭВШИЛ,  
ЗЭЭЛЭЭС ХАМААРНА
2. САЛБАРУУДЫН ӨӨРЧЛӨЛТ

**03** ТӨСВИЙН ОРЛОГЫГ ХЭРХЭН  
БҮРДҮҮЛЭХ ВЭ?


1. ОРЛОГЫН ТООЦООЛОЛ ӨӨДРӨГ БАЙНА

**04** ЭРСДЭЛҮҮД

**05** ТУНГААХ АСУУДЛУУД

**06** ХЭРЭГТЭЙ ХОЛБООСУУД

**07** САНАМЖ



# 1. 2026 оны төсвийн төслийг өргөн барив

2025.06.01

Нүүрсний үнийг 2025 оны төсөвт \$105 гэж тооцож байсан ч эхний таван сарын дунджаар нүүрсний үнэ \$72 буюу төлөвлөснөөс 32%-иар унав.

2025.06.27

Ерөнхий сайд Г. Занданшатар Монгол Улсын 2025 оны төсөвт хийх Хэмнэлтийн Тодотголыг танилцуулж УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлэв. Тэрбээр:

- “Нүүрсний үнийн огцом уналтаас голлон шалтгаалж төсвийн орлого ₮3.2 их наядаар тасалдах бодит нөхцөл байдал үүслээ. Энэ нөхцөл байдал цаашид даамжирч болзошгүй байна.”

2025.07.09

УИХ төсвийн тодотголын тухай хэлэлцэж 2025 оны төсвийн зарлагыг ₮1.9 их наядаар, орлогыг ₮3.3 их наядаар бууруулж, төсвийн алдагдлыг ₮1.4 их наяд (ДНБ-ий 1.5%) байхаар батлав.

2025.09.01

Ерөнхий сайд 2026 оны улсын төсвийн тухай болон холбогдох хуулийн төслүүдийг УИХ-ын дарга Д.Амарбаясгаланд өргөн барив.

- 2026 оны төсвийн төсөл иргэдийн оролцоонд тулгуурлаж, татварын ачааллыг бууруулахад чиглэсэн гэдгийг онцлов.

## 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛӨӨР:

📈 Орлого

₮31.6 их наяд

📉 Зарлага

₮33.0 их наяд

📊 Алдагдал

₮1.38 их наяд



## 2. Зарлагын өсөлтөө танахаас өөр гарцгүй болов

Нүүрсний үнийн уналтаас үл хамааран төсвийн хэмжээ түүхэндээ хамгийн өндөр түвшинд хадгалагдсаар байна.


Сүүлийн жилүүдэд төсвийн хэт тэлэлт огцом явагдсан:

- \$60-\$80-т зарж байсан чулуун нүүрсний үнэ цойлж 2021 онд \$176, 2022 онд \$205-т хүрсэн нь дараагийн жилүүдэд нь өндөр зарлага төсөөлөх шалтгаан болов.
  - Түүхий эдийн үнийн өөдрөг төсөөлөл, УИХ-ын сонгуулийн мөчлөг давхцаж, 2024 онд түүхэн дээд төсөв болох ₮30 их наяд зарлагатай төсвийг баталсан.
  - Зөвхөн УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагуудыг харахад 2025 оны нийт зардлын хэмжээ нь 2020 онтой харьцуулахад 2.3-10.7 дахин өссөн.
- 2022 оноос хойш нүүрсний үнэ жил тутам дунджаар ~30% буурч 2025.08 сард \$68-д хүрсэн нь **төсвийн зарлагын өсөлтөө бууруулахаас өөр аргагүйд хүргэв.**

Хэдий 4%-ийн зардлын өсөлт (₮31.6 их наяд → ₮33.0 их наяд) гэдэг бага сонсогдож байж болох ч нэгэнт өндөр түвшинд хүрсэн төсвийн зарлагыг дараа жилүүдэд бууруулахад хүндрэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл ирэх жилийн зарлагын өсөлт нь өмнөх жилийн өсөлтийг санхүүжүүлэхэд чиглэдэг.


### Өсөлт саарсан ч зарлага өндөр хэвээр

(Их Наяд ₮)




## 2.1. Зарлага – Иргэдэд чиглэсэн ч хувийн хэвшил, зээлээс хамаарна

E-Mongolia-аар дамжуулан хийсэн олон нийтийн хэлэлцүүлгийн дүнгээр: 1. Эрүүл мэнд (26.4%), 2. Боловсрол (21.4%), 3. Эрчим хүч (17.9%)-ний салбарын хөрөнгө оруулалтыг хамгийн ихээр нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Тэгвэл 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардал яг эдгээр 3 салбарт хамгийн их зарцуулагдах ч санхүүжилтийн гол ачааг гадаад зээл, хувийн хэвшил нуруундаа үүрч байна.




- Эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтыг **5.5 дахин** нэмэгдүүлэв.
  - Төсвийн хөрөнгө оруулалтаар ₮212 тэрбум, гадаадын зээл тусламжаар ₮1,090 тэрбум буюу нийт ₮1.3 их наядын санхүүжилт хийгдэнэ.
- **Зорилго:** хавдрын, зүрх судасны эмнэлэг барих, 17 аймгийн эмнэлгийн өргөтгөл гэх мэт асуудлыг шийднэ.



- Боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг **2 дахин** нэмэгдүүлэв.
  - Төсвийн хөрөнгө оруулалтаар ₮448 тэрбум, гадаадын зээл тусламжаар ₮594 тэрбум буюу нийт ₮1.0 их наядын санхүүжилт хийгдэнэ.
- **Зорилго:** 95 цэцэрлэг 108 сургууль барих, СӨБ, ЕБС хамрагдалтыг 100% болгох.




- Нийт хөрөнгө оруулалтын **65%**-ийг (₮2.6 их наяд) хувийн хэвшил санхүүжүүлнэ. Энэ нь эрчим хүчний салбар хувийн хэвшлээс хамаарна гэсэн үг.
- **Зорилго:** цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг, мөн төвлөрсөн дулаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн ам 99.7%- д хүрч, импортын цахилгаан эрчим хүчийг бууруулна.



## 2.2. Зарлага – Салбаруудын Өөрчлөлт

| Буурсан Салбарууд  | 2025<br>Тодотгол<br>(тэрбум ₮) | 2026<br>Төсөл<br>(тэрбум ₮) | Өөрчлөлт      |
|--|--------------------------------|-----------------------------|---------------|
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                   | 411                            | 259                         | <b>-37.0%</b> |
| Гадаад харилцааны сайд   | 261                            | 240                         | <b>-8.0%</b>  |
| Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд, эдийн засаг, хөгжлийн сайд | 259                            | 244                         | <b>-6.0%</b>  |
| Зам, тээврийн сайд   | 1,014                          | 980                         | <b>-3.3%</b>  |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                        | 663                            | 642                         | <b>-3.1%</b>  |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                     | 1,604                          | 1,599                       | <b>-2.8%</b>  |
| Монгол Улсын Ерөнхий сайд  | 381                            | 371                         | <b>-2.7%</b>  |
| Сангийн сайд   | 4,176                          | 4,068                       | <b>-2.6%</b>  |
| Боловсролын сайд   | 4,263                          | 4,210                       | <b>-1.3%</b>  |

| Өссөн Салбарууд                               | 2025<br>Тодотгол<br>(тэрбум ₮) | 2026<br>Төсөл<br>(тэрбум ₮) | Өөрчлөлт     |
|---|--------------------------------|-----------------------------|--------------|
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд | 261                            | 442                         | <b>69.4%</b> |
| Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд               | 47                             | 78                          | <b>65.5%</b> |
| Эрчим хүчний сайд                             | 365                            | 456                         | <b>24.7%</b> |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд | 441                            | 501                         | <b>13.6%</b> |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд | 82                             | 93                          | <b>13.5%</b> |
| Эрүүл мэндийн сайд                            | 1,720                          | 1,795                       | <b>4.4%</b>  |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд   | 4,495                          | 4,630                       | <b>3.0%</b>  |
| Батлан хамгаалахын сайд                       | 785                            | 790                         | <b>0.7%</b>  |



### 3. Төсвийн орлогыг хэрхэн бүрдүүлэх вэ?




- Нийгмийн Даатгалын Шимтгэлийн Орлого (НДШ), Орлогын албан татвар, Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ) нийлээд төсвийн орлогын ~73%-ийг бүрдүүлнэ.
- Хамгийн савлагаа ихтэй бүрдэл нь Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (АМНАТ): Төсвийн орлогын 13%-ийг дангаараа бүрдүүлж буй АМНАТ-ын орлогын тооцоололд эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөлөл, биет хэмжээний төсөөлөл, дэлхийн түүхий эдийн эрэлт тэр дундаа БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил чухал нөлөө үзүүлнэ.

**? Тунгаах асуулт:** АМНАТ-ыг тооцсон манай төсөөллүүд оновчтой байгаа юу?

- НӨАТ-ын орлого нь эдийн засгийн өсөлт, дотоод эрэлтээс хүчтэй хамааралтай тул ₮7 их наяд төсөөлөл хэт өөдрөг байж болзошгүй.


2026 оны төсвийн орлогын 94%-ийг татварын орлого, үлдсэн 6%-ийг татварын бус орлого бүрдүүлж байна.



Эх сурвалж: Сангийн яам



## 3.1. Орлогын тооцоолол өөдрөг байна

| <br>Чулуун нүүрс<br>(тонн тутамд) | 2025 он          |                  | 2026 он          |                     |
|--|------------------|------------------|------------------|---------------------|
|  | Төсвийн төсөөлөл | Бодит үнэ 8 сард | Төсвийн төсөөлөл | Fitch*-ийн төсөөлөл |
|  | \$105            | \$68             | \$70             | \$68                |

Эх Сурвалж: Сангийн Яам, Монголбанк, Fitch Ratings агентлаг

**\* Тайлбар** - Төсөвт нүүрсний дундаж үнийг урьдчилж тооцоход Австралийн коксжих нүүрсний үнийн трендийг хардаг. 2026 оны төсөвт 1 тонн Австралийн коксжих нүүрсний дундаж үнэ 2025-2026 онд \$175 хүрнэ гэсэн бол Fitch Ratings агентлаг \$170 (3%-иар бага) гэж одоогийн байдлаар таамаглаж байна. Энэ нь МУ 2026 онд 80 сая тонн нүүрс гаргасан ч бодит нүүрсний үнэ мөн адил 3%-иар бага байвал (\$70 → \$68) бид ₮575 тэрбум бодит алдагдал хүлээнэ гэсэн үг.

→ **Өөдрөг төсөөллийн шалтгаан:** ТБТХ-ийн 11.1.3.а заалтын дагуу өмнөх жилүүдийн дундаж болон олон улсын байгууллагуудын тухайн төсвийн жилийн өмнөх жилийн 3 сард зарласан төсөөллийг авч байгаа нь түүхий эдийн уналтын мөчлөг эхлэх үед хэт өөдрөг төсөөлөл хийх бас нэгэн үндэслэл болж байна.

2025 оны төсөвт тодотгол хийсэн гол шалтгаан нүүрсний үнэ болон биет хэмжээний хэт өөдрөг төсөөллөөс үүдэлтэй. Энэ нь төсвийн орлогын төлөвлөлтийг бодитой үндэслэлтэй тооцож чадаагүйг харуулна. Тус алдааг 2026 оны төсөвт дахин давтаж буй бөгөөд түүхий эдийн үнийн төсөөллөө боддог аргачлалаа өөрчлөх шаардлагатай эсэхийг анхаарах хэрэгтэй.

### Үнийн төсөөлөл өөдрөг байж болзошгүй

- 2026 оны төсвийн төсөлд Коксжих нүүрс, төмрийн хүдэр болон алтны үнийг 2025 оноос буурахаар төсөөлсөн ч олон улсын байгууллагуудын төсөөллүүдээс өндөр хэвээр байгаа нь **үнийн төсөөлөл өөдрөг байж болзошгүйг илтгэнэ.**

### Биет хэмжээний төсөөлөл өөдрөг байна

- Нүүрсний биет хэмжээг 2026 онд 90 сая тн-д хүрнэ гэж төсөөлсөн. Гэхдээ бид 2024 онд 79.5 сая тн, 2025 оны эхний 8 сард ердөө 49 сая тн-ыг л экспортолж чадсан.
- Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт 24 сар үргэлжлэх гэрээтэй тул 2027 оны 6-р сараас нааш нүүрс тээвэрлэлт хийгдэхгүй гэж үзвэл бид энэ жилийн хүчин чадлаараа экспортын тээврээ гүйцэтгэнэ гэж үзэж болно. Тэгэхээр биет хэмжээний төсөөлөл өөдрөг байгаа юм.

## 4. Эрсдэлүүд

### Эрсдэл 1: Эдийн засгийн өсөлт


- **Тодорхой бус байдал өндөр хэвээр.** 2026 оны эдийн засгийн өсөлтийг 5.7%-тай гэж төсөөлсөн байгаа нь өөдрөг төсөөлөл байж болзошгүй.  
→ Азийн хөгжлийн банк 5.9%, Дэлхийн банк 5.2% гэж төсөөлж буй.
- Эрдэс бүтээгдэхүүний экспортын орлого буурч, эдийн засгийн өсөлт саарч, хувийн хэвшлээс цугларах татварын орлого буурснаар төсвийн тусгай шаардлагадаа баригдан бид **дахиад тодотгол хийх эрсдэл үүснэ.**
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа энэ үед хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гэнэтийн шок тохиох эрсдэл өндөр байна. 2025 оны 8-р сарын инфляц 8.8% болж өсөх гол шалтгаан нь махны үнэ байв.
- **ЗГ-ын өр:** 2026 онд Номад бондын 176 сая ам.доллар, 2027 онд Сенчири-1 бондын 420 сая ам.долларыг төлөх хүлээлттэй байгаа нь нүүрсний үнийн үргэлжилсэн уналтын энэ цаг үед ханшинд давхар дарамт болж мөчлөгийг улам муутгах эрсдэл өндөр байгаа тул дахин санхүүжилт хийх арга хэмжээг эрт авах нь зүйтэй.

### Эрсдэл 2: Өөдрөг орлогын төсөөлөл

- 2025 оны төсөвт тодотгол хийсэн гол шалтгаан нүүрсний үнэ болон биет хэмжээний хэт өөдрөг төсөөллөөс үүдэлтэй гэж болно.
- Нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын **үнийн төсөөлөл өөдрөг байж болзошгүй.**
- Бид жилдээ 70-80 сая тонн нүүрс гаргадаг болоод байгаа тул нүүрсний үнэ ердөө 1\$-оор л унахад жилдээ 80 сая ам.доллар буюу **₮290 тэрбум** бодит алдагдал хүлээнэ.
- **Нүүрсний биет хэмжээний төсөөлөл өөдрөг байна.** 2026 онд ч мөн БНХАУ-ын нүүрсний хэрэглээ буурах хүлээлттэй байгаа.  
→ Дэд бүтэц, төмөр замын холболтоо сайжруулж, гэрээ хэлцэл сайн хийхгүй бол хилээр гаргаж чадаагүй 1 сая тн нүүрс тутмаас 68 сая ам.доллар (2025.08 сарын хилийн үнэ) буюу **₮243 тэрбум** алдах юм.

### Эрсдэл 3: Мөчлөг дагалт

- **Энэ удаагийн төсөв бол мөчлөг дагалт.** Эдийн засгийн өсөлтийн хурд саарсан, нүүрсний үнийн уналт үргэлжилсэн энэ үед инфляц өндөр хэвээр байгаа нь төсвийн тэлэх бодлого явуулах орон зайг өгөөгүй.
- Хөрөнгө оруулалтын зардалд олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн хүчтэй нөлөөлсөн. Эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцэд оруулж буй хөрөнгө оруулалтуудыг эдийн засаг өндөр өсөлттэй байгаа үед хийвэл зардал илүү бага тусах ч бид эдийн засгийн хүндрэлийн үетэй давхцуулж хийхээс аргагүйд хүрсэн.
- Олон нийтийн шахалтад баригдан төсвийг зохиож байгаа нь төсвийн бодлогын хараат байдалд **ноцтой хор уршигтай** зүйл юм.
- Бид төсвийн тусгай шаардлагадаа бүтцийн алдагдлын тооцооллыг нэвтрүүлж мөчлөгт уян хатан болох шаардлага бий. Энэ талаар бид эргэн танилцуулах болно.



## 5. Тунгаах Асуудлууд

### Асуудал 1: Эдийн засгийн өсөлт


Эдийн засгийн өсөлт төсөөллийн хэмжээнд хүрч чадахгүй болбол төсвийн орлогын 90%-иас дээш хэсгийг бүрдүүлж байгаа татварын орлого тасалдахад хүрнэ. Шинээр өргөн барих гэж буй татварын багц хуулийн төсөлд эдийн засгийн сөрөг шок нөлөөлөх үү?

### Асуудал 2: Өөдрөг орлогын төсөөлөл

Нүүрсний биет хэмжээг 90 сая тн буюу түүхэн дээд хэмжээнд хүргэх ямар төлөвлөгөө байгаа вэ? Нүүрсний үнийн төсөөлөл 2025 оны түвшинд хадгалагдахаар байгаа ч биет хэмжээний савлагаа орлогын шууд тасалдал үүсгэнэ.

### Асуудал 3: Мөчлөг дагалт

Төсөв үр ашигтай байх эсэх нь төсвийн бодлогын сахилга батаас хамаарахаар байна. 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтыг МУ-ыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй илүү уялдуулсан. Гэвч бид дунд болон урт хугацаанд энэхүү үзэл баримтлалаа тууштай хадгалж, үр дүн гаргаж чадах уу?



## 6. Хэрэгтэй холбоосууд

Монгол Улсын 2026 оны төсвийн баримт бичиг:

<https://online.flippingbook.com/view/533458506/18/>

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль:

<https://legalinfo.mn/mn/detail/503>

Монголбанк, гадаад секторын статистик, үзүүлэлт:

<https://stat.mongolbank.mn/external>

Үндэсний статистикийн хороо:

<https://www.1212.mn/mn>

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт:

<https://www.parliament.mn/nn/75212/>

Мэдээ:

<https://www.bloombergtv.mn/news/h1k1s7>

Гадаадын түүхий эдийн үнийн таамаглалууд:


<https://www.fitchratings.com/metals-mining#price-assumptions>

[https://app.powerbi.com/view?](https://app.powerbi.com/view?r=eyJrIjoiaMTUyMzZkNzYtMzBjNC00MGIwLWE3MTktN2YzOWQ0YjZmOGZhliwidCI6IjA3MDk5MWRkLWVjctNDc2Zi04MGRjLWU4YzNhOTFjNzBhZiJ9)

[r=eyJrIjoiaMTUyMzZkNzYtMzBjNC00MGIwLWE3MTktN2YzOWQ0YjZmOGZhliwidCI6IjA3MDk5MWRkLWVjctNDc2Zi04MGRjLWU4YzNhOTFjNzBhZiJ9](https://app.powerbi.com/view?r=eyJrIjoiaMTUyMzZkNzYtMzBjNC00MGIwLWE3MTktN2YzOWQ0YjZmOGZhliwidCI6IjA3MDk5MWRkLWVjctNDc2Zi04MGRjLWU4YzNhOTFjNzBhZiJ9)

Ашигласан зураг:

Mendsaikhan, U. (2022, May 24). an aerial view of a city with mountains in the background [Photograph]. Unsplash.



## 7. Санамж

Энэхүү бодлогын тоймд дурдагдах аливаа санал, бодлогын зөвлөмж, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Тинк Монгол Институт, түүний ажилтнууд, тоймд дурдагдсан байгууллагуудын албан ёсны байр суурийг заавал илэрхийлэхгүй бөгөөд 2025 оны 9-р сарын байдлаар олон нийтэд ил болсон мэдээлэлд үндэслэгдсэн болно. Энэхүү тоймд дурдагдсан тодорхой бодлого, засгийн газар, байгууллага, эсвэл бусад субъектүүд нь тухайн судлаач болон Тинк Монгол Институтээс тэдгээрийг дэмжиж, баталж, эсвэл эсэргүүцэж байгаа гэсэн утгыг агуулаагүй болно. Судлаач болон Тинк Монгол Институт нь энд агуулагдсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, цаг хугацааны хувьд аливаа баталгааг өгөхгүй бөгөөд дурдагдсан мэдээллийг ашигласнаас үүдэн гарах алдаа, орхигдол, үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Бүх мэдээлэл, эшлэлүүд нь олон нийтэд ил болсон, найдвартай гэж үзэж болох эх сурвалжаас авсан боловч тэдгээрийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд баталгаа өгөх боломжгүй. Энэхүү тойм нь зөвхөн мэдээллийн болон академик зорилгоор боловсруулагдсан бөгөөд санхүүгийн, хууль эрхзүйн, бодлогын зөвлөмж, заавар гэж ойлгож болохгүй. Уншигчид энэхүү мэдээллийг эх сурвалжтай тулган шалгаж, өөрийн дүгнэлт, шийдвэр гаргахыг зөвлөж байна. Судлаач болон Тинк Монгол Институт нь энэхүү баримт бичгийг хэрэглэснээс эсвэл түүний агуулгад тулгуурласнаас үүдэн гарсан шууд, шууд бус, санамсаргүй, эсвэл үр дагавартай аливаа хохиролд хариуцлага хүлээхгүй.

Энэхүү бодлогын тоймыг Тинк Монгол Институт боловсруулсан болно. Тоймын аливаа хэсгийг Тинк Монгол Институтээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хуулбарлах, тараах, нийтлэх, эсвэл өөр ямар нэгэн байдлаар ашиглахыг хатуу хориглоно. Зөвхөн тойм, шүүмж, нийтлэлд зориулж товч эшлэл ашиглахдаа зохих ёсоор эшлэл оруулсан тохиолдолд зөвшөөрөгдөнө.

Тинк Монгол Институт (Тинк Монгол) нь бие даасан судалгаа, санал санаачилгаар Монголын эдийн засгийн бодлогыг сайжруулах зорилготой нам бус, ашгийн бус эдийн засгийн бодлогын судалгааны институт юм. Тус институтийн гол судалгааны чиглэлүүд нь “Байгалийн нөөцийн эдийн засаг, засаглал,” “Төсөв, мөнгөний бодлого,” “Бизнесийн орчин ба өрсөлдөх чадвар” бөгөөд Тинк Монгол нь бодит ач холбогдол бүхий үзэл бодол, санаачилгын талбар болж, үр дүнд чиглэсэн судалгааг дэмжиж, Монголын ардчилал, эдийн засаг, нийгмийн ирээдүйг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.

Бидэнтэй холбогдох:

Facebook – [Тинк Монгол /Think Mongol/](#)

LinkedIn – [Think Mongol Institute](#)

Email: [ariunzaya@thinkmongol.mn](mailto:ariunzaya@thinkmongol.mn)

